

КОНЦЕССИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР

Төв аймагт 2010 онд Төр хувийн хэвшлийн зөвлөл байгуулагдсан гэх боловч албан ёсны бичиг баримт байхгүй байна. 2014-2016 онд хэрэгжүүлэх концессийн зүйлийн жагсаалтын санал боловсруулсан боловч аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй, судалгаа, үр ашгийн тооцоолол огт хийгээгүй, бодлогын баримт бичгийг боловсруулаагүй, концессийн гэрээгээр хийгдсэн ажил байхгүй байна.

Концессийн тухай хууль орон нутагт хэрэгжихгүй байгаа нь дараахь шалтгаануудаас болсон гэж үзэж байна. Үүнд:

1. Концессийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Эдийн засгийн хөгжлийн яам, Герман улсын Жи Ти Ай байгууллага болон Дэлхийн банктай хамтарсан сургалтанд 2012 онд хамрагдсан Хэлтсийн дарга, эдийн засагч нар солигдсоноос хойш энэ ажлыг тодорхой хариуцсан хүнгүй орхигдуулсан байна.

2. Эдийн засгийн хөгжлийн яамны сайд Н.Батбаярт аймгийн Засаг даргын 2014 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн 01/281 тоотойр “Орон нутгийн өмчийн концессийн зүйлийн жагсаалт”-ыг хүргүүлж хянуулахаар явуулсан боловч одоо хүртэл Эдийн засгийн хөгжлийн яамнаас хариу ирүүлээгүй байна. /ЭЗХЯ-нд явуулсан концессийн жагсаалтыг хавсарган хүргүүлэв/

3. Концессийн зүйлийн жагсаалтын саналаа Концессийн тухай хуулийн 9.7-д заасны дагуу Эдийн Засгийн Хөгжлийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүсэн боловч хариу ирүүлээгүйгээс тус хуулийн 10.2-т заасны дагуу аймгийн ИТХурлаар хэлэлцүүлж, батлуулах ажил хийгдэхгүй байна. Аймгийн ИТХурлын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 69 тоотойр аймгийн Засаг даргад Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарыг 10-нд хуралдах Тавдугаар хуралдаанаар аймгийн концессийн зүйлийн жагсаалтыг батлуулах асуудлын бэлтгэлийг бүрэн хангуулж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрийн төслийн хамт өргөн мэдүүлэхийг даалгасан боловч хэрэгжээгүй байна.

4. Концессийн зүйлийн жагсаалтын саналд тусгагдсан 4 бүлэг 10 зүйлийн жагсаалтаас 4 ажил нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаагаас үзэхэд концессийн зүйлийн судалгааг оновчтой хийгээгүй, хуулийн 10.3-д заасан шаардлагын дагуу боловсруулаагүйтэй холбоотой байна.

Ахлах аудитор

Ц.Базарсад

ҮАГ-ЫН НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Ерөнхий аудиторт 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Концессийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийгдэх нийцлийн аудитаар Төв аймгийн хэмжээнд Концессийн тухай хуулийн хүрээнд хийгдсэн ажил байхгүй тул дараах тайлбарыг хүргүүлж байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН